

## Хойнох үг

Манай ахмад үеийнхэн “Монголын судлал үүсээд 100 гаруй жил болоход олон улсын монголч эрдэмтэн харилцан нүүр учирч, хурал хийж байсан удаа үгүй. Ардын хувьсгалын ачаар тусгаар тогтносон Монгол Ард Улс бий болж, энэ 38 жилийн дотор манай улсад нам засгийн халамжаар шинжлэх ухаан хөгжиж, монголын судлалын талаар монгол эрдэмтэн төрж ирсэн нь дэлхийн олон улсын монголч эрдэмтний анхдугаар их хурал хийх бүрэн бололцоо бий болжээ” хэмээн үзэж 1959 оны 9 сарын 1-7-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо монголч эрдэмтний анхдугаар их хурлын хуралдааныг, 8-24-ны өдрүүдэд улс орны амьдрал ахуйтай танилцуулах аялалыг зохион байгуулсан юм. Энэхүү их хуралд Монгол Ард Улсаас гадна Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Унгар, Польш, Чехословак, Ардчилсан Солонгос Улс, Герман, Румын, Англи, Америкийн Нэгдсэн Улс, Канад, Япон, Энэтхэг эдгээр 15 улсын эрдэмтэн оролцож, гадаадын 14 улсаас 19 илтгэл, манай улсын эрдэмтдээс 14 илтгэл хэлэлцүүлсэн нь монголын судлалын салбарт ихэвчлэн гадаадын эрдэмтэн ажиллах явдал үгүй болж манай үндэстний боловсон хүчин – судлаачид энэхүү салбар шинжлэх ухаанд өөрийн гэсэн баттай байр сууриа хэдийн эзэлж эхэлснийг харуулах үйл явдал болсон юм. Тодруулбал хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Т.Пагва, “Төвд үсгээр үгчилсэн монгол ном зохиол”, профессор Ш.Лувсанвандан “Монгол хэл аялгууны учир”, профессор Ц.Дамдинсүрэн “Монгол уран зохиолын судлалын зарим асуудал”, доктор профессор Б.Ринчен “Монгол бэнсний үлгэр”, эрдэм шинжилгээний ахлах ажилтан Я.Цэвэл “Монгол албан бичгийн уламжлал” мөн ахлах ажилтан Б.Содном “Дашдоржийн Нацагдоржийн уран зохиолын тухай”, эрдэм шинжилгээний ажилтан Э.Вандуй “Орчин цагийн монгол нэр томьёоны тухай”, эрдэм шинжилгээний ахлах ажилтан А.Лувсандэндэв “Гучин зургаат тайлбар толийн тухай”, дэд эрдэмтэн Л.Мишиг “Монгол ард улсын зарим нутгийн хамниган аялгууг сурвалжилсан нь”, эрдэм шинжилгээний ажилтан Э.Оюун “Монгол ардын харилцаа дууны тухай”, эрдэм шинжилгээний ажилтан Г.Ринченсамбуу “Монгол ардын дууны төрөл зүйл”, МУИС-ын төвд хэлний багш Дорж гавж “Төвд монгол дохионы бичиг, түүвэр нэрсийн тухай”, мөн Гомбожав гавж “Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын тухай” гэсэн илтгэлүүд хэлэлцүүлсэн нь цөм монголын судлалд урьд өмнө гараагүй шинэ сэргэг шинжтэй байжээ. Чухам ингэж илтгэгч хийгээд тэдний илтгэлийн сэдвийг сонгох тал дээр хурлыг зохион байгуулагчид ихээхэн анхаарал тавин ажиллаж байсан ажээ. Үүнийг тодруулах баримтын нэг бол энд толилуулсан академич Ш.Лувсанванданы “Монгол хэл аялгууны учир” хэмээх өгүүлэл болно.

Уг олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлыг 1959 оны намар Улаанбаатар хотноо хийхээр санаачилсныг төр засгаас ихэд сайшааж дэмжин тусалсан байна. Тухайлбал, 1958 оны 11 сарын 15-д их хурлын бэлтгэл ажлыг хангах комисс байгуулсан ба улмаар 1959 оны 1 сарын 10-д уг комиссыг бэлтгэл хороо болгон өргөтгөжээ. Тус хороонд даргаар Цэвэгмид, нарийн бичгийн даргаар Лувсандэндэв, гишүүнээр Дамдинсүрэн, Жаргалсайхан, Ринчен, Содном, Ванган, Жалан-Аажав, Тойв нарыг баталсан байна. Энэхүү хорооны гишүүд хурлын бэлтгэлийг чамбай гүйцэтгэж, илтгэл тавих төлөөлөгч нэг бүртэй тусгайлан харилцаж байжээ. Тухайлбал, хурлыг санаачлагчдын нэг, Хэл бичгийн кабинетийн дарга Б.Ринчен тухайн үед Бээжингийн Их Сургуульд монгол хэлний багшаар ажиллаж байсан Ш.Лувсанванданд “Таны биеийг монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хуралд илтгэх монгол эрдэмтний бүрэлдэхүүнд оруулсныг мэдэгдье. Таны нэг илтгэлийг Монгол хэл аялгууны учир гэж төлөвлөсөн. Үүнд монгол хэлийг халимаг хэл, буриад хэл гэх зэргээр хуваадгийг хэлний шинжлэлийн үндэс баримт хаашаа болохыг гаргамуй. Халимаг хэл гэж Ижил, Донын их, бага дөрвөд, торгуудын аялгууг нэрлэдэг бол манай Увс, Ховдын дөрвөд,

торгууд, урианхайг бас тусгай хэлтэн гэж үзэх, эсвэл орос үг олон орсноор халимаг, буриад нь тусгай хэл гэх болов уу, автономит улс болохдоо аялгуу нь хэл болдог юу уу? гэж бодмоор. Тус их хуралд ирэх эрдэмтэн бүхэн монголын судлалд шинэ нээлт болох илтгэл хийх тул дэлхийн эрдэмтний сонирхол татах бөгөөд тэдний мэддэггүй зүйлээс илтгэл хийх тул Танд илтгэлийн сэдэв, хэмжээний хувьд сонгон тогтоох бүрэн бололцоо олгоё” хэмээсэн байдаг. Энэ хүсэлт ёсоор Ш.Лувсанвандан гуай “Монгол хэл аялгууны учир” хэмээх өгүүллийг бэлдсэн байна. Тус өгүүлэл тухайн үеэс хойш хэдэнтээ хэвлэгдэж (1959; 1961; 2002; 2009; 2010) бас хятад (1959), япон (1960) зэрэг хэлээр орчуулагдсан юм. Хэдий тийм боловч МУИС-ын ахмад багш нарын нэг Ш.Лувсанванданы энэ өгүүллийг оюутан суралцагчдад зориулан дахин хэвлэн нийтэлж байна. Учир нь юуны өмнө энэхүү өгүүлэлд дэвшүүлсэн монгол хэл аялгууны ангиллыг эдүгээ хүртэл сургалт, судалгаанд онцын өөрчлөлтгүй баримталсан хэвээр байгаа билээ. Нөгөөтэйгүүр энэ өгүүлэл нь хэлний аливаа үзэгдлийг талаарх Ш.Лувсанвандан гуайн судалгааны хандлагыг тод харуулах жишээ болж буйгаараа залуу судлаачдад онол-аргазүйн чухал гарын авлага болох юм. Тодруулбал, академич Ш.Лувсанвандан судалгааны бүтээлүүддээ уг асуудлын талаарх өмнөх судлаачдын бүтээлүүдийг нэг бүрчлэн авч үзэх бөгөөд тэдгээрийн шинэлэг тал болон дутагдалтай зүйлийг нь тодорхой дурдаад, түүнийхээ үндсэн дээр өөрийн саналаа дэвшүүлээд, эцэст нь тухайн үеийн ерөнхий хэл шинжлэлийн шинэ чиг хандлага, онол, үзэл бодлыг тусгайлан өгүүлсэн байдаг юм. Тэрбээр “Монгол хэл аялгууны учир” хэмээх энэхүү бүтээлдээ ч гэсэн монгол хэл аялгууг ангилсан А.Руднев, Б.Я.Владимирцов, Г.Д.Санжеев, Н.Поппе, Чингэлтэй нарын судалгааг түүхчлэн авч үзжээ. Ингэхдээ тэдний саналын ололттой хийгээд дутагдалтай талыг тодорхой дурдсан байдаг. Үүний дараа орчин цагийн монгол хэл аялгууны талаарх өөрийн ангилал, саналыг тодорхой өгүүлсэн байна. Улмаар уг ангиллынхаа дагуу аялгуунуудыг үгсийн сангийн талаар харьцуулан үзэж хоорондоо хэр ойрхон бас хол гэдгийг тодруулжээ. Тухайн үед буюу 1950-аад оны эхээр Америкийн хэл шинжлэлч, антропологич М.Сводеш хэлнүүдийн салсан он цагийг тогтоох үгийн сангийн статистик судалгааны арга боловсруулсан бөгөөд Японы эрдэмтэн Ш.Хаттори уг аргыг хэрэглэн эртний япон хэлний аялгуунуудын салсан цагийг тогтоох оролдлогыг 1954 онд хийсэн байна. Улмаар 1959 онд монгол хэлнүүдийн салсан оны талаарх өгүүлээ “Gengo Kenkyu” [Хэл шинжлэл] сэтгүүлд хэвлүүлжээ. Тухайн үед ийнхүү ерөнхий хэл шинжлэлд шинэ тутам үүсээд монгол судлалд дөнгөж орж ирж байсан судалгааны шинэлэг аргатай Ш.Лувсанвандан гуайн энд толилуулж буй өгүүллийн үзэл санаа яв цав тохирч байгаа нь уг эрдэмтэн цаг үетэйгээ хэрхэн хөл нийлүүлэн алхаж байсны тодорхой гэрч юм. Ш.Лувсанвандан гуай Ш.Хатторигийн “Монгол хэлнүүдийн салсан оныг судлах нь” гэсэн дээрх өгүүллийг монгол хэлнээ орчуулж хэвлүүлсэн билээ.

Б.Түвшинтөгс